



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 02 сарын 27 өдөр

Дугаар A/115

Ховд


Г Эзэмшил газрын хэмжээ, талбай
өөрчлөх тухай Г

Монгол Улсын Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалт, Хаягжуулалтын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 4.3 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 267 дугаар тогтоол, 2016 оны 55 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн
ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жаргалант сумын Алагтолгой баг 1 дүгээр гудамжны 1 б тоотод байрлах Отгонжаргалын Анхбаяр /ОЭ79101010/ 824 метр квадрат газрыг мэдээллийн сангийн зургийн дагуу 847 метр квадрат, Барилгачдын 1 дүгээр гудамжны 104 тоот болгон худалдаа, нийтийн үйлчилгээний зориулалтаар 15 жилийн хугацаагаар өөрчлөн эзэмшүүлсүгэй.
2. Газрын хэмжээ талбай өөрчлөгдж байгаа иргэнд газраа зориулалтын дагуу үр ашигтай, зүй зохистой эзэмшиж, хамгаалж, газар эзэмшүүлэх гэрээнд заасан нөхцөл болзлыг биелүүлж ажиллахыг үүрэг болгосугай.
3. Газар эзэмших эрх баталгаажсан иргэнтэй газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, газар эзэмших эрхийн гэрчилгээ олгон, газрын төлбөрийг хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэн гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Б.Баярсүх/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ



Zax A/115 Ch
02 00526